

**МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧЛАГЫН
АЖЛЫН ХЭСГИЙН 65 ДУГААР ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ /2025-10-24/**

Ажлын хэсгийн 65 дугаар хуралдаан 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 9.00 цагт "Пума" зочид буудлын 2 дугаар давхарын хурлын танхимд зохиогдов.

Хуралдаанд Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын шинжээч П.Туул, Татварын ерөнхий газрын том татвар төлөгчийн газрын улсын байцаагч Б.Түвшинжаргал, Ашигт малтмал газрын тосны газрын мэргэжилтэн С.Баттулга, Авилгатай тэмцэх газрын комиссар А.Тэрбиш, ажилтан Р. Бямбасүрэн, Бадрах Энержи ХХК-ийн мэргэжилтэн Н.Буянхишиг, "Эрдэнэс Монгол" Нэгдлийн мэргэжилтэн Б.Сарана, МУУҮА-н менежер Б.Саранцэцэг, Нүүрс Ассоциацийн нарийн бичгийн дарга Б. Эрдэнэцэцэг, "Оюутолгой" ХХК-ийн ахлах менежер Г.Сугар, "Петрочайна дачин тамсаг" ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч Ц. Болормаа, "Петроматад" ХХК-ийн менежер С. Амаржаргал, "Хүний эрх хөгжил" ТББ-ын тэргүүн Г.Уранцоож, "Захиргааны шинэ санаачлага" ТББ-ын тэргүүн С.Цэрэнпүрэв, "Ховдын толь" ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Д.Цэдэнбал, "Монголын байгаль эхийн аврал сан" ТББ-ын тэргүүн Н. Наранцэцэг, "Транспаренси Интернейшнл Монгол" ТББ-ын тэргүүн Э.Мөнхжаргал, "Хил хязгааргүй алхам" ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, "МБОИЗ-ийн Байгаль орчны ерөнхий зөвлөл"-ийн хяналтын хорооны дарга Чинзориг, ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч Ш. Цолмон нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 19 гишүүн оролцож, ирц 57.6 хувьтай байв.

Мөн хуралдаанд "СИКА" ХХК-ийн гүйцэтгэх захирал Ж. Эрдэнэбилэг, дэд захирал Г. Эрдэнэ, хэлтсийн захирал Т. Түмэнчимэг, судалгааны менежер Б. Удвал, О. Энхзул болон "Гроүт Финанс Аудит" ХХК-ийн аудитор Т. Ганбат, ОУИТБС-ын олон нийт, орон нутаг хариуцсан ажилтан Б. Хосбаяр, санхүүгийн ажилтан А. Отгонтунгалаг, мэдээлэл технологийн зөвлөх Х. Хулан нар оролцлоо.

Хуралдааныг ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч Ш. Цолмон нээж, хурлын хөтөлбөр, дотоод журмыг танилцуулав.

Танилцуулга нэг: Монголын ОУИТБС-ын 2024 оны буюу 19 дүгээр нэгтгэл тайлангийн төсөл

Монгол Улсын ОУИТБС-ын 2024 оны буюу 19 дүгээр нэгтгэл тайлангийн төслийг "СИКА" ХХК-ийн дэд захирал Г. Эрдэнэ цахимаар танилцуулав. /Танилцуулгыг хавсаргав/

Ш.Цолмон: Г.Эрдэнэ захиралд их баярлалаа. Энэ 2024 оны буюу 19 дүгээр нэгтгэл тайланг дэлгэрэнгүй сайхан танилцуулж өглөө. Гишүүд маань өөрсдийгөө танилцуулаад, асуултаа тавина уу.

С.Цэрэнпүрэв: За баярлалаа, СИКА-гийн тайлантай 4 дахь жилдээ танилцаж байна. Бид Иргэний нийгмийн протоколоор ажилладаг, үүрэг даалгавар өгчихсөн, бидний чадамжийг хүртэл үнэлчихсэн байна. Энэ зарчим дээр улсын төсвийн орлого, зарлагын талаарх олон нийтийн ойлголт, тогтвортой хөгжлийн төлөө бодитой оновчтой тэгээд шийдлүүдийн талаар нийтэд мэдээлж, хэлэлцэж, тусалж

чадна гээд биднийг үнэлсэн байж байгаа. Ер нь бид нарт зөвлөмж өгөх эрх байхгүй. Компаниудад зөвлөмжөө өгөөд ажиллах ёстой. Хэрвээ компаниудын тайланг хүлээж авах явцад асуудал байвал иргэний нийгэмтэй хамтраад явж болно. Би эрх бүхий уул уурхайн чиглэлийн аудитор, тэгээд би танай тайланг хараад бид нартай хамтраад ажиллаад үнэлж байгаа бол хүлээн зөвшөөрнө, хамтарч ажиллаагүй байж энэ зөвлөмжийг би хүлээн зөвшөөрөхгүй. Гуравдугаарт тайлангийн 344 хуудас дотор 152-оос хойш нь тэр компаниудын ямар ч мэдээлэлгүй маш олон хуудас хоосон явж байгаа. Компаниудаас мэдээллээ авах ёстой биз дээ. Авч чадахгүй байгаа бол бидэнд бас энэ тал дээр ажиллаж болох олон нөхцөл нь байгаа. За тэгээд миний асуултуудад хариулж өг.

Г.Эрдэнэ: За тэгье, уучлаарай би зөвлөмжийн хэсгээ танд жоохон буруу ойлгогдохоор хэлчихсэн юм шиг байна. Манай баг Монголын ОУИТБС-ын энэ тайланг илүү чанаржуулахын тулд иргэний нийгмийн байгууллагуудаа татан оролцуулах, дэмжихэд ажиллаж байна. Ялангуяа иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхжуулах чиглэлд техникийн болон бусад менежментүүдийн туслалцаа үзүүлэх бөгөөд иргэний нийгмийн байгууллагууд мониторинг хийдэг билээ. Ийм боломжийг бас давхар олговол тайлагнал маань илүү сайжрах байх гэдэг үүднээс бид энэ зөвлөмжийг оруулсан юм. Хэрвээ та бүхэн ийм байх боломжгүй гэж бодож байвал бид энэ зөвлөмжийг авч болно. Би сая ярихдаа ч гэсэн буруу ойлгуулсан байна уу гэж бодлоо. Ер нь бол иргэний нийгмийн байгууллагууддаа илүү дэмжих тал дээр л зөвлөмж оруулсан.

М.Чинзориг: Өглөөний мэнд, Байгаль орчны ерөнхий зөвлөлийн хяналтын хорооны дарга, Чинзориг байна. Тайлангийн агуулгуудад хуучнаасаа ахиц дэвшил гарсан байна. Нөгөө шүүмжүүдийг хүлээн авсан байна. Дээр нь ялангуяа энд 45 аж ахуйн нэгжийг иргэний нийгмийн саналаар судалгаанд хамруулсан байна. Эндээс яг аймаг, аймгаар нь гаргасан мэдээлэл байна уу, мөн нэгдүгээрт, Өмнөговь аймаг хэдэн аж ахуйн нэгж байна, хоёрдугаарт, 7 аж ахуйн нэгж огт мэдээлэл өгөхгүй гээд саад бэрхшээл учруулсан гэж байна. Энийг Зөрчлийн тухай хуулиар холбогдох байгууллагад нь хандсан уу, эдгээр байгууллагуудад зохих албан бичгүүдийг явуулсан уу? Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны хууль эрх зүйн хэлтэст нь хандаж ямар зөвлөмж, зөвлөгөө авсан бэ? Гуравдугаарт, орон нутгийн байгууллагатай, орон нутгийн удирдлагуудтай харьцахад байгууллагын нууцын зэрэглэлд аваад мэдээлэл өгөхгүй гэсэн гэж ярилаа. Тэгэхээр энэ хэдэн байгууллага нууцын зэрэглэлд мэдээллээ оруулсан байна вэ? Энэ талаар бас аж ахуйн нэгжүүдийн судалгаа байна уу?

Г.Эрдэнэ: За 7 аж ахуйн нэгжүүдээс бид мэдээллийг нь авч чадаагүй, тэд татгалзсан. Гэхдээ бид ингээд орхиогүй. Энэ компаниудаас мэдээлэл авахын тулд ОУИТБС-ын ажлын хэсэг бас иргэний нийгмийн байгууллагууд эдгээр компаниуд руу холбогдох байдлаар дахин дахин хүсэлт, албан бичгүүдийг явуулж ажиллаж байсан. Харин зөрчлийн хуулиар арга хэмжээ авна гэдэг юм уу, эсвэл энэ компаниудыг мэдээллээ өгөхгүй бол ийм торгуулийн арга хэмжээ авахуулмаар байна гэдэг байдлаар бусад хуулийн гэдэг юмуу улсын байцаагчдаар шахуулах арга хэмжээ аваагүй, зөвхөн бид өөрсдийн зүгээс хүсэлт өгөх байдлаар ерөнхийдөө ажилласан байгаа. Эдгээр аж ахуйн нэгжүүд нь аль аль аймгийнх вэ гэдэг дээр манай багийнхан одоо хариулчих байх. Зарим аймгууд бас байгууллагуудын мэдээллийг бидэнд өгөхдөө аж ахуйн нэгжүүдийн нууцтай холбоотой мэдээллүүдийг бид нар өгч тараахгүй, энэ бол нууц мэдээлэл гэдэг байдлаар хандаж байсан.

Д.Цэдэнбал: Би Ховд аймгийн ОУИТБС-ын салбар зөвлөлийн гишүүн байна. Энэ тайлантай холбогдуулаад 1-2 зүйлийг асууя. Миний асуух гэсэн зүйлийг М.Чинзориг дарга бас асуулаа. Энэ 45 аж ахуйн нэгжийг сонголоо гэсэн, яаж сонгоод ямар аж ахуйн нэгж орсон юм, энэ дотроос 21 аймгаас, тухайлбал 21 аймагт чинь бүгдэд нь салбар зөвлөл байгуулагдчихсан ажиллаад байдаг юм. Бид нар 2016 оноос хойш л ийм салбар зөвлөл байгуулаад яваад байдаг. Яг ямар аймагт үйл ажиллагаа явуулдаг вэ? Аж ахуйн нэгжийг тэр сонгоод, өөрөө хамтраад явсан юм байна шүү дээ. Энэ ажлаа иргэний нийгмийн байгууллагууд, салбар зөвлөлийн гишүүдээс саналыг нь авч оруулсан уу, юу баримталж ажилласан бэ гэдгийг тодруулна уу. Уг нь тэр зөвлөмж өгч байхын оронд бүүр эхнээс нь иргэний нийгмийн байгууллагад 21 аймгийн салбар зөвлөлүүдээс оролцох нэг аж ахуйн нэгж сонгоё гээд нэг сонгож болдоггүй юм уу? Энэ дотроо ер нь аль аймгаас аль аймгийн салбар зөвлөлтэй нэгдэв ээ гэдгийг тодруулж өгөөч ээ гэж нэгдүгээрт хүсье. Хоёрдугаарт, бидний гол зорилго бол өгсөн авснаа ил тод хийгээд, энэ нь зөрүүгүй байх л ёстой. Тэгтэл 17 их наядын зөрүү гарчихсан байна. Би энийг ойлгохдоо нөгөө аж ахуйн нэгж нь өгчихсөн гэж тайлагнаад нөгөө тал нь орлого ирээгүй гэж тайлагнаад ийм зөрүү гарчихдаг юм болов уу. Энэ зөв үү? Ийм их том зөрүү гараад байхад энийг одоо буцааж төлүүлэх, үгүй бол одоо энэ дунд нь дарагдуулсан нь хариуцлагаа ер нь яаж тооцдог юм бэ, энэ дээр хариуцлага тооцох механизмаа зохих хууль эрх зүйн байгууллагад дамжуулсан уу?

Мөн манай Ховд аймагт Тефис майнинг, тэгээд дахиад цаана нь одоо бид нарын анхаарал татаад байгаа тэр Халзан бүргэдэй орд ороод ирчихсэн байж байгаа. Цаана нь дахиад вольфрамын ордууд байж байгаа. Ийм их том том ордуудтай ийм аймгууд дээр ер нь яаж ажиллах вэ? Ийм 3 асуудалд надад хариулт өгнө үү.

Г.Эрдэнэ: 45 аж ахуйн нэгж бол төрийн бус байгууллагуудын саналаар сонгож авсан. Бид 2025 оны 7 дугаар сард эхлэлийн тайлангийн хурлыг хийсэн байгаа. Эхлэлийн тайлангийн хурал дээрээ энэ удаагийн тайланд хамрагдах 110 аж ахуйн нэгжүүдийг сонгож 2 талаасаа зөвшилцсөн. Энэн дээр бид хэд орлогыг тодорхойлох аж ахуйн нэгжүүдээс гадна, эрсдэлтэй гэж хэлж болох энэ 45 жижиг аж ахуйн нэгжүүдийг нэмж оруулъя гэдэг байдлаар төрийн бус байгууллагуудаасаа санал аваад төрийн бус байгууллагууд маань бүгдэд нь бичиг хүргүүлсэн байгаа. Тэгээд бүх ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийг бол харамсалтай нь бид нар оруулж чадаагүй. Нийтдээ 100-аад аж ахуйн нэгжүүдийг ирүүлсэн байсан. Тодорхой тоог нь санахгүй байна. Тэгэхдээ бид хэд тэндээсээ эрэмбэлэлт хийж байгаад 7 дугаар сард хийсэн хурлаараа ингээд 45 аж ахуйн нэгжүүд зөвшөөрөгдөөд ингээд бид хэд сонгож аваад явсан байгаа юм. Нэг аймгаас нэг аж ахуйн нэгж гэдэг ч юм уу, ийм байдлаар бол яваагүй, ерөөсөө төрийн бус байгууллагууд маань санал өгсөн байдлаар л явсан. Энэ санал ирэх гэж бас их удсан. Ер нь цаашдаа бол энэ аж ахуйн нэгжүүдийн хувьд хавар болгон төрийн бус байгууллагуудын саналыг бол авдаг, тэгээд зөвшилцөөд оруулдаг энэ байдал цаашаагаа уламжлал болоод тогтмол явах болов уу гэж би бодож байна аа.

Тэгэхээр 3 дахь асуултад энэнтэйгээ холбоотой хамт хариулчихъя. Тийм. Тэгэхээр гол асуудал бол жижиг аж ахуйн нэгжүүд дээр байдаг, том аж ахуйн нэгжүүд бол харьцангуй тайлан мэдээлэл бүх юмаа өгөөд, тогтчихсон байдаг. Жижиг аж ахуйн нэгжүүд маань тайлан өгөхөөс цааргалдаг, тодорхой мэдээллүүдээ нууцалдаг, ийм зүйлүүд бол буруу байна гэдгийг одоо бид бүхэн бүгдээрээ л мэдэж

байгаа шүү дээ. Тэгэхээр энэ жижиг аж ахуйн нэгжүүдийг яаж тайланд хамруулах вэ, яаж бүртгэл сэргээх вэ, яаж мэдээллийн ил тод байдлыг сайжруулах вэ гэдэг дээр төрийн байгууллага болон иргэний байгууллагуудын бүх талуудын хамтын ажиллагаа хамгийн чухал юм байна гэдгийг нь харж байгаа. Тийм ч учраас бид нар зөвлөмждөө энэ жижиг аж ахуйн нэгжүүдийг тайланд хамруулах, жижиг ч гэхгүй бүх аж ахуйн нэгжүүдийг бүрэн дүүрэн алдаагүй хамруулдаг байхад бүгдээрээ ямар байдлаар анхаарах вэ гэдэг байдлаар би зөвлөмжөө өгсөн байгаа.

За 2 дахь асуулт дээр тэр зөрүүтэй холбоотой асуудлууд ярьж байна. Зөрүүтэй холбоотой нийтдээ 17 их наядын зөрүү үүсчихсэн гэж та ойлгож болохгүй. Нарийн тоонуудыг манай аудитор хэлэх байх. Ер нь бол энэ нэг талаас компанийн талаас улсын төсөвт төлснөө бүгдийг нь тайлагнаж байгаад нөгөө талаас Засгийн газар талаасаа хүлээж авсан орлогуудаа сайхан тайлагнаж байгаад энэ 2-ыг хооронд нь уяад, зөрөө үүсвэл тэр зөрөөг нь магадлах аль нэг нь одоо магадгүй тоо алдчихсан байж болно, техникийн болоод янз бүрийн алдаа байж болно. Тэгэхээр энэ зөрөөг бид нар магадлах, тодруулах байдлаар нь аль болох зөрүүг нь арилгаад, компани талаасаа хэдэн сая төгрөгийн татвар төлсөн юм байна, Засгийн газарт бол тэдэн сая төгрөгийн татвар хүлээж авсан байна гээд бид тохируулах байдлаар ажилласан. Энэ бүхнийг манай аудитор дэлгэрэнгүй тайлбарлаад өгчих байх аа. Г.Ганбат хариулах уу?

Т.Ганбат: Энэ бол анхны тайлан. Нэгтгэлийн зөрүү. Хамгийн анх бид нар 7 сард нэгтгэл хийхэд ийм зөрүүтэй байсан гэсэн хүснэгт юм. Одоо 22 тэрбум болж багассан гэсэн үг. Орон нутгаас 17 тэрбум, улсын хэмжээнд 5 тэрбум, тэгээд нийлээд 22 тэрбумын зөрүү одоо байгаа гэсэн үг.

Д.Цэдэнбал: Тэр компанийн сонголт, хамтын ажиллагаа гэсэн хүснэгт дээр байна л даа.

Т.Ганбат: Тийм. Энэ бол хамгийн эхний тайлангийн зөрүү. Залруулга хийхээс өмнөх зөрүү гэсэн үг. Залруулга хийсний дараа 17 их наяд нь 22 тэрбум болж багассан гэсэн үг.

Ж.Эрдэнэбилэг: Сика компанийн гүйцэтгэх захирал Ж.Эрдэнэбилэг байна. Сая Г.Эрдэнэ захирал маань уг нь хариулах шиг болсон. Тэгээд би дэлгэрүүлж бас тайлбарлая гэж бодож байна. Миний ойлгож байгаагаар бол бид бүхэн судалгаа хийгээд, тооцооллуудыг нь тал талаас нь аваад ил тод байлгахын тулд залруулгыг нь хийгээд ингээд гаргаж байгаа. Эрх зүйн хувьд болбол бид дараагийн акц хийх, дараагийн хариуцлагажуулах үйлдлүүд хийх эрх бидэнд байхгүй.

Ш.Цолмон: Би зөрүүтэй холбогдуулаад тодруулга хийе. Одоо энэ асуудлыг сар орчмын дараа Үндэсний зөвлөлд оруулна. Тэгэхээр манай аудитор, энэ байгууллага маань үргэлжлүүлээд бас энэ зөрүүг арилгах, багасгах, учир шалтгааныг нь олох талаас нь ажилладаг юм. За тэгээд нэгтгэл тайлангаа эцэслээд Үндэсний зөвлөлд оруулж батлуулдаг ийм журамтай. Бидний зорилго бол мэдээллийг ил тод болгож, олон нийтэд харуулдаг. Тэрнээс хариуцлага хүлээлгэдэг тийм эрх бидэнд байхгүй. Тийм учраас бид нөгөө хуулийн төслийг яриад байгаа юм.

М.Чинзориг: Уг нь жижиг аж ахуйн нэгж гэж ярих ёсгүй, тэгж хэлдэг, оруулмааргүй л байгаа юм. Бүх аж ахуйн нэгж тэгш эрхтэй, адилхан эрх авчихсан учраас жижиг нэг өөр эрх зүйн орчинтой, том нэг өөр эрх зүйн орчин гэж байхгүй шүү дээ. Бүгдээрээ Монгол Улсын хэмжээнд эрх зүйн орчин нэг л байгаа. Энийгээ

дагуулаад та нар яриандаа ч гэсэн бас хэллэгүүдээ өөрчилмөөр юм байна. Тэгэхээр энийгээ та нар анхаараад энэ дээр санал оруулъя гэсэн юм. Би мөн Байгаль орчны иргэний зөвлөлөөс санал оруулж байна, энэ мэдээгээ өгөхгүй байгаа газруудыг олон нийтэд ил болгох юм уу, нэр төрд нь халдах юм уу, хар дансанд оруулах юм уу, энэ талаар та нар өөрсдийнхөө саналыг дэвшүүлээч гэсэн саналтай байна.

Г.Эрдэнэ: За баярлалаа, ойлголоо, таны саналыг сонслоо. Ер нь бол цаашид бүх аж ахуйн нэгжүүдтэйгээ нэгтгэл тайланд яаж идэвхтэй хамруулах вэ, бүгдийг нь яаж тайланг нь ил тод, дэлгэрэнгүй болгох вэ? Тэр талд нь бүх шатны, энэ ажилд оролцож байгаа бүх хүмүүс тодорхой хэмжээнд бодож, санаа оноогоо уралдуулж яаж сайжрах вэ гэдэгт бодож явдаг гэж ойлгож байна. Тэгэхээр цаашид яаж сайжруулах вэ гэдэг дээр яаж ямар байдлаар зөвлөмж өгөх вэ гэдэг дээр бас эргээд бас та бүхэнтэйгээ ярилцъя.

Г.Уранцоож: Хүний эрх хөгжил төв. Манайх бол ТАН эвслийн гишүүн байгууллага. Тэгээд энэ ажлын хэсэгт бас гишүүн. За энэ баг маань бол 4 дэх удаагаа тайлан хийж байна. Мэдээж сайжраад байгаа гэж үзэж байна. Танайх 4 удаа хийхэд ямар ямар зөвлөмжүүдийг өгч байсан бэ? Тэгээд хэрэгжсэн үү, үгүй юү гэдгийг нь нэг ийм ганц хүснэгт гаргаад хавсаргачихвал их зүгээр байна. Тэгвэл Үндэсний зөвлөл дээр ч гэсэн харахад хүнд хэрэгтэй, энэ ажил ингээд хийгдэж байгаа, ийм ач холбогдолтой. Ийм юмнууд нь сайжирч байна. Ийм юмнууд нь бол яг давтагдаад байна аа, эсвэл бүүр зарим нь жаахан тийм байна шүү гээд. Яагаад гэвэл түрүүний зөвлөмж дээр харагдаж байсан идэвх санаачилга нь буураад байна гэсэн, тэр маш ноцтой байхгүй юу. Гэтэл бид нарт энэ яалт ч үгүй маш хэрэгтэй ажил байгаад байдаг. Мэдээж хэрэг, тэр эрх зүйн зохицуулалтууд бол их хэрэгтэй байгаа. Тэгээд одоо удахгүй энэ шинэ Засгийн газрын ажлын мөрийн хөтөлбөрт энэ орсон байх гэж би бодож байна. Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт энийг би орсон байгаа байх л гэж бодоод байх юм. Тэгэхээр одоо дараа жилийн ажлын төлөвлөгөөнд нөгөө энэ хуулийнхаа талаар бас яаж урагшлуулах асуудал дээр ер нь нэлээн анхаарч ажиллах ёстой юм байна. Тийм болохоор хэдүүлээ ямар ч байсан нэг хуультай болж явах ёстой байх, хуультай болтлоо энэ ажлыг бол их сайн үргэлжлүүлж хийх шаардлагатай байна. Тэгээд болж өгвөл ийм юмгүйгээр аль аль талаасаа Засгийн газар талаасаа Засгийн газрын байгууллагууд, тэгээд компани талаасаа одоо дүнгээ гаргаад, тэгээд зөрүүгөө өөрсдөө хоорондоо ярилцаад тохируулдаг тийм хэмжээнд л уг нь очих ёстой гэж бодоод байгаа. Тэгэхээр тэр болтол нь л ер нь бол энэ ажил явах ёстой. Тэгэхээр миний ганцхан хэлэх гээд байгаа юм бол тэр нэг хүснэгтийг та нар хийчихвэл ядахдаа энэ ажил ингээд ийм хэрэгтэй байгаа шүү гэдэг юмыг ойлгуулаад авч явах ёстой байх.

Г.Эрдэнэ: Тэгье ээ.

С.Цэрэнпүрэв: Зөвлөмж дээр бас өөр энэ компаниудыг жаахан шахах гэж оруулмаар байна, энэ олон улсын стандартын тайлан гаргаснаар энэ том биржүүд дээр их үнэлгээ авдаг байхгүй юу. За манай Монголын энэ компаниуд доош нь унагаагаад байгаа. Тэгэхээр Монгол банкны хуульд ч юм уу оруулах хэрэгтэй байна. Тэгэхлээр тийм нэг хөшүүрэг баймаар байх юм. Та нар энэ жилийнхээ зөвлөмжид оруулчихвал яадаг юм бэ. 19 дэх тайлан гарч байхад Монгол улсынхаа ямар нэгэн хуульд оруулчихгүй яваад байгаа шүү дээ. Ашигт малтмалынхаа хууль дотор ч гэсэн бүрэн орохгүй яваад байгаа. Тэгээд энэ сайн дураараа гэдэг үгэн дээр бас манай

зөвлөлийн гишүүд үүнийг шүүмжлээд байгаа шүү. Тэгэхээр энэ дээр нэг ийм зөвлөмж хийгээрэй. 2 дугаарт орон нутгийн компаниуд тайлангаа муу гаргаад байна гэж байна. Засгийн газар аймгуудын дарга нарыг хүлээн авч уулздаг. Тэр аймгуудын дарга нарын уулзалт дээр энэ тайлангаа танилцуулах хэрэгтэй. Ямар үр дүнтэй, ашигтай юм гээд. Нөгөөтэйгүүр иргэн бид нар чинь бас энэ тайлангуудыг чинь орон нутагруу явахдаа сайн тарааж өгдөг. Бид нар бас тийм үүрэг рольтой оролцдог байхгүй юу. Тэр ролийг та нар муу үнэлсэн байна шүү. Би бол иргэн нийгэмд 25 жил ажиллаж байгаа болохоор иргэний нийгмийг сайн байхын төлөө явдаг хүн.

Г.Эрдэнэ: За ойлголоо. Баярлалаа.

С.Баттулга: Саяхан манай Ашигт малтмал, газрын тосны газраас имэйлээр нэг тайлбар хийчихсэн байгаа. Улсын зардлаар хийгдсэн ордуудын геологийн зардлуудыг төлдөг. Буцаагаад үүний явцын талаар нэлээн сайн мэдээ дамжуулж өгсөн байгаа. Энийг та хэд тэр тайландаа сайн бичвэл зүгээр юм байна. Урьд нь бид нар тухайн жилдээ тийм байгууллага өчнөөн мөнгө төллөө гэсэн тоо өгдөг байсан. Энэ жил болохоор хэчнээн байгууллагууд энэ гэрээг байгуулсан бэ, хэчнээн нь мөнгөө яаж өгч байгаа вэ, төлөөд дууссан нь хэд юм бэ гээд нэлээд дэлгэрэнгүй судалгаа өгсөн. Энийг нэгтгэл тайлан дээрээ бичвэл иргэний нийгмийн байгууллагын хүмүүс ч гэсэн үзэж харж байхад их зөв зүйтэй мэдээ байгаа.

Ш.Цолмон: За, Баярлалаа. Надад ганц 2 санал байгаа. Нэгдүгээрт өнөөдрийн гишүүдээс гарсан саналын дагуу тайланг засаад Үндэсний зөвлөлд танилцуулах бэлтгэл ажлыг ойрын хугацаанд хийнэ гэж найдаж байгаа. Хоёрдугаарт англи орчуулга нэлээн хоцордог, онд давах гээд байдаг гашуун туршлагатай. Тэгэхээр та бүхэн энийг анхаараарай. Мөн орчуулгын чанар дээр анхаараарай. Үүнээс гадна Бадрах энерги төслийн талаар нэг товч танилцуулга орох ёстой юм. Тэр сонгосон 45 компанитай холбогдуулаад аль аль аймагт, хаана хаана үйл ажиллагаа явуулдаг билээ. Тусад нь нэг хүснэгт гаргана уу. Тэр 7 компанитай холбогдуулаад аудиторынхаа зүгээс ямар санал байдаг юм оруулна биз ээ. Үндэсний зөвлөлд түүнийг нь танилцуулаад тэндээс шийдвэр гаргуулна гэж бодож байна.

Мөн Сика компанитай байгуулсан гэрээний үлдэгдэл төлбөр 40% буюу 43.6 сая төгрөгийг хуваарийн дагуу төлөхийг зөвшөөрөх үү гэсэн шийдвэр гарах ёстой. Ингээд та бүхэн зөвшөөрч байна уу?

Оролцогчид: Санал нэг байна.

Ш.Цолмон: За баярлалаа.

Д.Цэдэнбал: Манайх их анхаарал татаад байгаа нэг аймаг байгаа шүү дээ. Тийм учраас энэ 2026 ондоо тэр манай аймагт салбар зөвлөлийг идэвхжүүлэх тал дээр сургалт семинарыг зохион байгуулж өгнө үү гэж хүсэлт тавих гэсэн юм аа.

Б.Хосбаяр: Орон нутаг хариуцсан мэргэжилтэн Б.Хосбаяр байна. Сая баруун бүсийн чуулга уулзалт болох гэж байгаад цуцлагдчихсан. Тэнд очиж дэд зөвлөлийнхөнтэй уулзаж бас төлөвлөгөөгөө ярилцъя гэж бодож байсан юм. Биечлэн уулзахын хувьд. Онлайнаар бол бид нар байнга харилцаатай байгаа. Дэд зөвлөлийнхөнтэй, ялангуяа төрийн байгууллагынхантайгаа онлайнаар сургалт, уулзалтуудаа явуулж байгаа. Байнга, цаг үеийн мэдээллийг өгч байгаа.

С.Цэрэнпүрэв: Энэ хуулийн ажлын хэсгийнхний сонсгол эсвэл ажлын тайланг сонсмоор байна. Хууль зүй дотоод хэргийн яамны сайт дээр байж л байх юм. Эсвэл

НҮБ-д захидал бичвэл яадаг юм, одоо манай энэ ажлын албаныхан ч юм уу, эсвэл манай иргэний нийгэм ч юм уу. Бид нар бас энэ стандартын хүрээнд энэ санаачилгын хүрээнд төрийн нарийн бичгийн даргатай уулзъя гэж санал өгсөн байгаа. Хариу өгөөгүй байгаа.

Танилцуулга хоёр: Монголын ОУИТБС-ын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, 2026 оны төлөвлөгөөний төсөл.

ОУИТБС-ын ажлын албаны зохицуулагч Ш. Цолмон 2025 оны төлөвлөгөөний биелэлтийн явц болон 2026 оны төлөвлөгөөний төслийн талаар товч танилцуулав. /танилцуулгыг хавсаргав/

С.Баттулга: 2026 оны төлөвлөгөөний төсөлтэй танилцлаа. Жишээлбэл тайлангуудыг 100% авдаг болно гэж бичсэн байна. Манайх бол өөрийн гэсэн хуультай, хэрвээ тайлангаа өгөөгүй байгууллагыг торгодог торгуультай, тэрнийхээ мөнгөн дүнг хууль дээр зарлачихсан. Ингээд байхад манайд бол би сая тоо авлаа, өнөөдрийн байдлаар 84% нь л тайлангаа өгдөг. Тэгэхээр хуультай, торгоод байхад байгууллагууд ингээд тайлан өгөхгүй байхад ямар ч хуульгүй зүгээр сайн дураар бол энэ тайлангуудыг 100% авна гэж байхгүй байх. Тийм учраас биелэх боломжтой тоо тавиарай гэсэн санал өгч байна. Дараа нь яамны болоод манай байгууллагын гадагшаа тавьдаг илтгэл мэдээлэл дээр ОУИТБС-ын тайланг, эсвэл ажлын явц гэсэн ганц нүүр мэдээлэлтэй бичвэл тун зүгээр байна. Үүнийгээ мөн яамны илтгэлүүд дээр оруулаад өгчихдөг байвал хэрэгтэй юм болов уу.

Н.Баярсайхан: За сайн байцгаана уу, Хил хязгааргүй алхам төрийн бус байгууллагын тэргүүн. Энэ материалуудтай танилцсан, нөхцөл байдал зарим талаараа бол ахицтай байна, зарим талаараа бол бас зогсонги, ухралттай юмнууд бол ажиглагдаж байна. Ямар ч төсөвгүйгээр 2026 онд энэ ажлуудыг хийх юм байна гэж санаа зовж байна. Тэгэхээр шинэ стандартын хувьд бол энэ жендер, нийгмийн нөлөөллийг үнэлж өгөхийн хувьд их чухал заалт. Яагаад гэвэл энэ уул уурхайн салбарын өгөөж нь жендерийн хүртээмжтэй, нийгмийн ахиц өөрчлөлт гаргаж байж энэ бол бас үр нөлөөтэй гэж энэ харагдана. Австралийн Транспаренси интернэйшнал байгууллага, байгалийн нөөцийн хүрээлэн, Дэлхийн банкны хамтарсан "Олон талт итгэлийн" сан гэж байдаг. Тэр сангаас санхүүжилттэй төслийг энэ 2 байгууллага дээр хэрэгжүүлж байна. Зөвхөн бид нар төлбөр орлогын мэдээлэлээс гадна энэ нийгмийн үзүүлэлтүүдийг анхаарч байх хэрэгтэй гэдэг үүднээс нь сонирхож байна гэсэн саналаа бичсэн. Гол шаардлага нь бол ОУИТБС хэрэгждэг улс орон байна гэсэн. Тэгээд энэ дээр манайх тэнцэж байгаа учраас бас их боломж байна. Тэгээд энэ утгаараа дэмжлэгээ авсан. Миний гаргах бүтээгдэхүүн бол ерөөсөө жендерийн үр нөлөөг гаргая, үр үзүүлэлтийг гаргая, маягттай больё.

Хоёрдугаарт бол орон нутгийн түвшинд олон талт хэлэлцүүлгүүдийг бид нэлээн сайн хийж байсан. Иргэний нийгмийн байгууллага бол анхнаасаа 2004, 2005 оноос эхлүүлээд бүр сумын түвшинд очиж хийж байсан туршлага бол байгаад байгаа. Манай аж ахуйн нэгжүүд ч бас нэлээн сайн дэмжиж оролцдог. Тэгээд энэ юмаа сэргээх, одоо орон нутгийн удирдлагууд их залуужиж байна, шинэ болж байна. Тэгээд тэд нарт бол ийм удирдамж, гарын авлага, чиглүүлэг бол хэрэгтэй байгаа. Тэгэхээр сумын түвшиндээ уул уурхайн компани, нутгийн захиргаа, иргэдийгээ оролцуулсан олон талт хэлэлцүүлэг хийх, энэ удирдамжийг гаргая, мөн жендерийн

үнэлгээ гэсэн ийм 2 зүйлийг гаргах зорилгоор боловсруулсан юм. Тэгэхээр энэ ажлын төлөвлөгөөг хараад уялдуулах юм юу байна вэ гэдгийг харахаар 1, 2 зүйл байх шиг байна. Илүү тодорхой болгоод энэ дээр бас саналаа оруулаад хэлье гэж ингэж бодож байна, саналаа өгье.

Ш. Цолмон: За баярлалаа. Тэгэхээр жендерийн асуудал бол манай ОУИТБС-ын стандартын шинэ шаардлагуудын нэг. Манай компаниуд жендерийн асуудал, тухайлбал ажилтны тоогоо эрэгтэй, эмэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй гэдгээр тайлагнаж байгаа.

Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон хуралдааны шийдвэрийн төслийг уншиж танилцуулав, Гишүүд 100 хувь санал нэгтэй дэмжив.

Ш.Цолмон: За ингээд өөр саналгүй бол та бүгдэд өнөөдрийн хуралдаа оролцож санал бодлоо уралдуулж, идэвхтэй оролцсонд талархлаа илэрхийлээд энэ удаагийн хурлаа өндөрлөж байна.

Хуралдаан 12:00 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

АҮЭБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга:

 Б.Дашпүрэв

Тэмдэглэлийн хянасан:
АҮЭБЯ-ны СХОХ-ийн дарга

 Т.Амартүвшин

Хуралдааныг даргалсан:

ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч

 Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ОУИТБС-ын Ажлын албаны мэдээлэл
Технологийн зөвлөх

-2  Х.Хулан



АЖ ҮЙЛДВЭР,
ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ



Extractive Industries
Transparency Initiative

UHY GROWTH FINANCE
GROWTH FINANCE AUDIT LLC



МОНГОЛ УЛСЫН АРВАН ЕСДҮГЭЭР БУЮУ 2024 ОНЫ **НЭГТГЭЛ ТАЙЛАН**

Олборлох үйлдвэрлэлийн ил тод
байдлын санаачилга

Судалгаа, зөвлөх үйлчилгээний Эс Ай Си Эй ХХК, Гроут
Финанс аудит ХХК-ийн гүйцэтгэв.



АГУУЛГА

КОМПАНИ СОНГОЛТ,
ХАМТЫН АЖИЛЛАГАА

01

ОУИТБС-ЫН ОРЛОГЫН
БУС МЭДЭЭЛЭЛ

03

02

04

ЗӨВЛӨМЖ

НЭГТГЭЛ
ТОХИРУУЛГЫН ҮР ДҮН

1 КОМПАНИ СОНГОЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Төслийн үйл ажиллагааны шат дараалал



1 КОМПАНИ СОНГОЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Хараат бус нэгтгэгчийн бүрэлдэхүүн



ГҮЙЦЭТГЭГЧ БАГЫН БҮРЭЛДЭХҮҮН

БАГЫН АХЛАГЧ

Г.Эрдэнэ

Эс Ай Си Эй ХХК-ийн Дэд захирал,
Докторант

ТАЙЛАНГИЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Т.Түмэнчимэг

Эс Ай Си Эй ХХК-ийн Судалгааны хэлтсийн захирал

Б.Удвал

Эс Ай Си Эй ХХК-ийн Судалгааны хэлтсийн менежер

О.Энхзул

Эс Ай Си Эй ХХК-ийн Судалгааны хэлтсийн менежер

АУДИТ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Б.Бямба

Гроут Финанс аудит ХХК-ийн Аудитор,
мэргэшсэн нягтлан бодогч

Т.Ганбат

Гроут Финанс аудит ХХК-ийн Аудитор, нягтлан бодогч

2024 оны 19 дүгээр нэгтгэл тайлангийн үндсэн багт нийт 6 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаад байна.

01




КОМПАНИ СОНГОЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

1 КОМПАНИ СОНГОЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА


Компанийн сонголт

ОҮИТБС-ын тайланд хамрагдсан компанийн тоо, нэгтгэгдсэн мөнгөн дүн, тэрбум төгрөгөөр:



1 КОМПАНИ СОНГОЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

ОУИТБС-ын тайлан ирүүлсэн компанийн мэдээлэл



1 КОМПАНИ СОНГОЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Материаллаг байдал ба цар хүрээг тодорхойлох нь


Урьдчилсан шинжилгээний үр дүн

№	АНГИЛАЛ	ЗГ-ЫН ТАЙЛАГНАСАН КОМПАНИЙН ТОО	ЗГ-ЫН ТАЙЛАГНАСАН ДҮН	ЭЗЛЭХ ХУВЬ	КОМПАНИЙН ТАЙЛАГНАСАН ТОО	КОМПАНИЙН ТАЙЛАГНАСАН ДҮН	ЭЗЛЭХ ХУВЬ	АНХНЫ ЗӨРҮҮ
1	100 тэрбум дээш	8	6,989.9	87.3%	7	6,433.5	87.5%	556.4
2	1 тэрбум-100 тэрбум	85	951.3	11.9%	63	863.2	11.7%	88.1
3	500 сая-1 тэрбум	33	22.9	0.3%	28	19.9	0.3%	3.1
4	300 сая-500 сая	22	8.6	0.1%	30	11.8	0.2%	-3.2
5	300 сая хүртэл	705	31.9	0.4%	657	20.4	0.3%	11.5
НИЙТ		853	8,004.7	100.0%	785	7,348.7	100.0%	656.0

1 КОМПАНИ СОНГОЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА


2024 оны нэгтгэл тайланд хамруулах компанийн сонголт

**ТББ-аас хамруулах хүсэлтэй байсан 45 аж ахуйн нэгжийн саналыг авч, ОУИТБС-ын 2024 оны тайлангийн хамрах хүрээг ОТАХ-ийн гишүүд баталсан.*




1 КОМПАНИ СОНГОЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Материаллаг байдал ба цар хүрээг тодорхойлох нь



110 компанийн мэдээлэл, ашигт малтмалын төрлөөр, тэрбум төгрөг



Нэгтгэл тайланд хамрагдсан ААН-ийн төлсөн татварын дүн нийт Засгийн газрын хүлээн авсан орлогод эзлэх хувь

Нэгтгэл тайлан	Хамрагдсан компани	ЗГ-ын хүлээж авсан нийт орлогод эзлэх хувь	Компаниудын нийт төлбөрт эзлэх хувь
14-р нэгтгэл тайлан	171	92.8%	85.0%
15-р нэгтгэл тайлан	60	82.0%	78.0%
16-р нэгтгэл тайлан	60	94.3%	84.0%
17-р нэгтгэл тайлан	104	97.0%	98.2%
18-р нэгтгэл тайлан	125	98.8%	99.2%
19-р нэгтгэл тайлан	110	90.5%	98.6%


1 КОМПАНИ СОНГОЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Материаллаг байдал ба цар хүрээг тодорхойлох нь


Сонгогдсон ААН-ээс Засгийн газрын хүлээн авсан орлого, тэрбум төгрөгөөр, өмчийн хэлбэрээр /сая.төгрөг/

2024 он	ЗГ-ын хүлээн авсан орлого	ААН-ийн тайлагнасан орлого	Анхны зөрүү
НИЙТ ДҮН	7,697,158.5	6,456,992.9	1,240,165.6
Төрийн өмчит ААН	5,815,281.8	5,308,899.0	506,382.8
Хувийн хэвшлийн ААН	1,881,876.7	1,148,093.9	733,782.8

Нэгтгэл тайланд орох ААН-ийн өмчийн хэлбэр



Сонгогдсон ААН-ээс Засгийн газрын хүлээн авсан орлогын бүтэц, хувиар



02



НЭГТГЭЛ ТОХИРУУЛГЫН ҮР ДҮН

2 НЭГТГЭЛ ТОХИРУУЛГЫН ҮР ДҮН

Анхны тайлагнасан төлбөр, орлого болон нэгтгэлийн тохируулга, хамрагдсан 110 компаниар, сая төгрөгөөр



- Анхны нэгтгэлээр 1,566,890.8 сая төгрөгийн зөрүү үүссэн.
- ЗГ-ын тайланд 4,272,885.5 сая төгрөгийн нэмэгдэх тохируулга, компанийн дүнд 5,862,304.8 сая төгрөгийн нэмэгдэх тохируулга хийгдсэн.
- **Эцсийн тайлбарлагдаагүй зөрүү (22,528.5) сая төгрөг болгож тохируулга хийсэн.**

2 НЭГТГЭЛ ТОХИРУУЛГЫН ҮР ДҮН

Анхны тайлагнасан төлбөр, орлого болон нэгтгэлийн тохируулга, сая төгрөгөөр

ТАЙЛАН ГАРГАГЧ	КОМПАНИЙН ТОО	УЛСЫН ХЭМЖЭЭНД	ОРОН НУТГИЙН ХЭМЖЭЭНД	НИЙТ
Анхны тайлан				
ЗГ-н байгууллага, орлого	110	7,697,158.5	50,599.3	7,747,757.8
Хувийн компаниуд, Төлбөрүүд	103	1,148,093.9	36,936.6	1,185,030.6
ТӨААН-үүд, Төлбөрүүд	7	5,308,899.0	443,318.1	5,752,217.1
Анхны нэгтгэлийн зөрүү		1,240,165.6	-429,655.5	810,510.1
Нэгтгэл				
ЗГ-н тохируулга		1,375,322.7	661,869.3	2,037,192.0
Компанийн тохируулга		2,621,003.4	249,228.1	2,870,231.5
ЗГ-н дүн тохируулгын дараа		9,072,481.2	712,468.6	9,784,949.8
Компанийн дүн тохируулгын дараа		9,077,996.3	729,482.8	9,807,479.1
Эцсийн тайлбарлагдаагүй цэвэр зөрүү		-5,515.1	-17,014.2	-22,529.3


№	ОРЛОГЫН УРСГАЛ	Засгийн газрын хүлээн авсан орлого		Компани тайлагнасан төлбөр	
		Компани	Дүн	Компани	Дүн
1	Анхны тайланд дутуу тайлагнасан	81	296,856.3	81	1,864,362.4
2	Анхны тайланд илүү тайлагнасан	81	1,864,362.4	81	296,856.3
3	ЗГ талаас мэдээлэл ирээгүй	24	80,347.7	14	12,028.8
4	Гаалийн үйлчилгээний хураамж, гаалийн албан татвар болон гаалийн НӨАТ-н төлбөрүүдийг хооронд нь зөрүүтэй тайлагнасан.	5	22,080.2	11	29,285.5
5	Суутган татварын дүнгээр зөрүүтэй	-	-	78	1,937,204.9
6	Мөнгөн сууриар бүртгээгүй	2	299.8	2	1,819.2
НИЙТ		193	2,263,946.5	267	4,141,557.0

2 НЭГТГЭЛ ТОХИРУУЛГЫН ҮР ДҮН

Засгийн газрын хүлээн авсан орлого, байгууллагаар, сая төгрөгөөр

■ Компанийн дүн (тохируулгын дараа)

■ ЗГ-ын дүн (тохируулгын дараа)



Үзүүлэлт	Дүн			
	2021	2022	2023	2024
ЗГ-ын дүн (тохируулгын дараа)	3,252,574.5	5,275,365.6	8,305,472.4	9,784,949.8
Компанийн дүн (тохируулгын дараа)	3,252,593.8	5,282,472.2	8,439,143.5	9,807,479.1
Нийт зөрүү	-19.3	-7,106.6	-133,671.1	-22,529.3
Тохируулгын хүсэлтэд хариу ирүүлээгүй компани	-	9.0	5.0	7.0
Тайлбарлагдаагүй цэвэр зөрүү	-19.3	-7,106.6	-133,671.1	-22,529.3
ЗГ компаниудаас илүү тайлагнасан	6,778.9	136,725.1	190,615.3	6,966.7
ЗГ компаниудаас дутуу тайлагнасан	-6,798.2	-129,618.5	-324,286.3	-29,496.1

2 НЭГТГЭЛ ТОХИРУУЛГЫН ҮР ДҮН

Хамгийн өндөр төлбөр төлсөн топ 20 компани, сая төгрөгөөр


№	РД	КОМПАНИ	ДҮН	ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ
1	5435528	Эрдэнэс Таван толгой ХК	3,376,453.1	37.2%
2	2074192	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	1,466,338.3	16.2%
3	2657457	Оюутолгой ГХО ХХК	829,963.2	9.1%
4	2887746	Энержиресурс ХХК	640,392.8	7.1%
5	2095025	Монголын Алт МАК ХХК	572,950.0	6.3%
6	2016656	Тавантолгой ХК	523,176.5	5.8%
7	5084555	Саусгоби сэндс ГХО ХХК	266,122.5	2.9%
8	2075385	Петрочайнна дачин тамсаг ГХО ХХК	215,058.2	2.4%
9	5199077	Өсөхзоос ХХК	188,118.5	2.1%
10	2094533	Бороогоулд ГХО ХХК	101,615.9	1.1%
11	5261198	Си Өү Эй Эл ХХК	96,968.6	1.1%
12	2887134	Хангад-Эксплорэйшн ГХО ХХК	96,679.8	1.1%
13	5352827	Цагаан-Өвөлжөө ХХК	63,850.6	0.7%
14	5671833	Хур эрдэнэ баялаг ГХО ХХК	62,823.3	0.7%
15	2550466	Эрдэнэс критикал минералс ТӨҮГ	62,728.6	0.7%
16	6413811	Хан алтай ресурс ХХК	58,062.2	0.6%
17	2548747	Цайртминерал ГХО ХХК	56,085.2	0.6%
18	2855119	Болдтөмөр ерөө гол ГХО ХХК	55,878.4	0.6%
19	2008572	Багануур ХК	32,237.7	0.4%
20	2807459	Тефисмайнинг ХХК	31,329.4	0.3%
НИЙТ			8,796,832.7	96.9%

Компанийн тайлагнасан төлбөрийн мэдээг Засгийн газрын тайлагнасан орлогын дүнтэй тохируулсны дараа шинжилж үзэхэд 2024 онд топ татвар төлөгч 20 компани нь нийт **8,796,832.7 сая төгрөг буюу нийт мөнгөн дүнгийн 96.9 хувийг** төлсөн байна.

2 НЭГТГЭЛ ТОХИРУУЛГЫН ҮР ДҮН

Олборлох салбарын өсөлт, сая төгрөгөөр


Олборлох үйлдвэрлэлийн салбарын нийт орлого нь топ татвар төлөгч 5 компанийн үйл ажиллагаатай шууд хамаарч байна. Топ татвар төлөгч 5 компани нь **сүүлийн 5 жилд нийт 25,621.4 тэрбум төгрөгийн татварыг улсад төлсөн** байна.



Топ татвар төлөгчид	2020	2021	2022	2023	2024
Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	984,198	965,261	1,785,363	1,985,520	1,466,338.3
Оюу Толгой ГХО ХХК	532,245	916,185	589,259	734,901	829,963.2
Эрдэнэс Таван толгой ХК	468,569	294,949	1,052,562	2,854,882	3,376,453.1
Энержи Ресурс ХХК	182,244	50,975	308,384	414,198	640,392.8
Монголын Алт МАК ХХК	75,515	122,587	103,807	336,822	572,950.0
Нийт дүн	2,242,771	2,349,957	3,839,378	6,326,325	6,886,097.4
Өсөлтийн хувь	-13%	7%	77%	65%	8.8%

2 НЭГТГЭЛ ТОХИРУУЛГЫН ҮР ДҮН

Маягтаар авсан мэдээлэл, ирүүлсэн ААН-ийн тоогоор



03



ОҮИТБС-ЫН ОРЛОГЫН БУС МЭДЭЭЛЭЛ

3 ОҮИТБС-ЫН ОРЛОГЫН БУС МЭДЭЭЛЛҮҮД

Ил тод болох мэдээллүүд

“ОҮИТБС-ын стандарт 2023” дагуу хэрэгжүүлэгч орнуудад тавигдах шаардлагуудыг хэрэгжүүлэх хүрээнд нэгтгэл тайланд орох орлогын бус мэдээллийг цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх үйл явцыг хэрэгжүүлэв.

АҮЭБЯ

3

ОҮИТБС-ын шаардлага 2.1, 2.4,

АМГТГ

11

ОҮИТБС-ын шаардлага 2.2, 2.3,
3.1, 3.2, 3.3, 4.2, 6.3

СЯ

10

ОҮИТБС-ын шаардлага 2.1, 4.6,
5.1, 5.2, 5.3

ТӨБЗГ

5

ОҮИТБС-ын шаардлага 2.6, 4.2,
4.5, 6.2

ЗТЯ

2

ОҮИТБС-ын шаардлага 4.4

ТЕГ

2

ОҮИТБС-ын шаардлага 4.1, 4.7

ГБХНХЯ

3

ОҮИТБС-ын шаардлага 6.1

БОУАӨЯ

1

ОҮИТБС-ын шаардлага 6.4

3 ОҮИТБС-ЫН ОРЛОГЫН БУС МЭДЭЭЛЛҮҮД

Уул уурхайн салбарын үндсэн үзүүлэлтүүд



ДНБ-ий оны үнээрх өсөлтийг уул уурхайн салбараар авч үзвэл 2024 онд өмнөх оноос 1,988.0 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй, уул уурхайн салбар нийт ДНБ-ын 27.3 хувийг бүрдүүлж байна.

3 ОУИТБС-ЫН ОРЛОГЫН БУС МЭДЭЭЛЛҮҮД

Ашиглалт болон хайгуулын тусгай зөвшөөрөл



Тусгай зөвшөөрлийн төрөл	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Шинээр олгосон	90	163	93	238	105
Талбай буцаасан	71	26	34	27	28
Цуцалсан/хүчингүй	140	75	45	39	47
Дуусгавар болгосон	133	120	100	27	57
Шилжүүлсэн	83	74	63	92	101
Сунгуулсан	68	246	291	94	304
Барьцаалсан	27	38	22	21	21
Барьцаа чөлөөлсөн	28	16	23	31	31
Нөхөн олгосон	17	11	6	11	15

3 ОУИТБС-ЫН ОРЛОГЫН БУС МЭДЭЭЛЛҮҮД

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрийн хэмжээ

№	БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТӨРӨЛ	ХЭМЖИХ НЭГЖ	2023 он	2024 он
1. Уул уурхай, олборлолт				
1.1	Нүүрс	мян.тн	81,304.9	97,721.5
1.2	Газрын тос	мян.бар	4,888.9	4,188.3
1.3	Зэсийн баяжмал	мян.тн	1,395.3	1,562.2
1.4	Молибдений баяжмал	тн	5,643.7	5,498.2
1.5	Цэвэршүүлээгүй алт	кг	14,854.8	12,594.9
1.6	Төмрийн хүдэр	мян.тн	5,334.8	6,642.2
	Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	2,304.4	3,470.0
1.7	Хайлуур жоншны хүдэр	мян.тн	304.1	431.2
	Хайлуур жоншны баяжмал	мян.тн	188.4	127.1
1.8	Цайрны баяжмал	мян.тн	402.9	552.2
1.9	Мөнгөний баяжмал	тн	16,454.0	15,637.0
2. Боловсруулах үйлдвэр				
2.1	Баяжуулсан нүүрс	мян.тн	6,979.4	8,041.6
2.2	Нүүрсэн шахмал түлш	мян.тн	504.6	511.4
2.3	Катодын зэс 99%	тн	9,661.3	6,976.3
2.4	Металл бэлдэц	тн	37,680.5	35,987.1
2.5	Металл цувимал	тн	36,117.9	35,031.8
2.6	Ган төмөр хийц	тн	6,195.7	4,504.5

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс 16,416.6 мян.тн буюу 20.2 хувь, зэсийн баяжмал 166.9 мян.тн буюу 12.0 хувь, төмрийн хүдэр 1,307.4 мян.тн буюу 24.5 хувь, төмрийн баяжмал 1,165.6 мян.тн буюу 50.6 хувь, хайлуур жоншны хүдэр 127.1 мян.тн буюу 41.8 хувь, цайрын баяжмал 149.3 мян.тн буюу 37.0 хувиар тус тус өссөн байна.

Харин молибдены баяжмал 145.5 тн буюу 2.6 хувь, алт 2,259.8 кг буюу 15.2 хувь, хайлуур жоншны баяжмал 61.2 мян.тн буюу 32.5 хувиар, мөнгөний баяжмал 817.0 тн буюу 5.0 хувиар тус тус буурсан байна.

3 ОУИТБС-ЫН ОРЛОГЫН БУС МЭДЭЭЛЛҮҮД

Уул уурхайн голлох бүтээгдэхүүний экспортын мэдээлэл

Эрдэс бүтээгдэхүүний экспортын биелэлт, голлох бүтээгдэхүүнээр



Эрдэс бүтээгдэхүүний экспортын дундаж үнэ

Төрөл	Хэмжих нэгж	12 дугаар сар (өссөн дүнгээр)		Өөрчлөлт	
		2023	2024	Зөрүү	Хувь
Чулуун нүүрс	тн/ам.дол	131.4	107.3	-24.1	-18.3%
Зэсийн баяжмал	тн/ам.дол	1,721.7	1,957.7	236.0	13.7%
Төмрийн хүдэр, баяжмал	тн/ам.дол	77.8	79.6	1.7	2.2%
Цайрын хүдэр, баяжмал	тн/ам.дол	1,462.2	1,452.3	-9.8	-0.7%
Жоншны хүдэр, баяжмал	тн/ам.дол	250.4	232.6	-17.7	-7.1%
Молибдены баяжмал	тн/ам.дол	18,939.0	15,993.6	-2945.40	-15.6%
Алт	тн/ам.дол	62,897.7	77,233.0	14,335.3	22.8%



Нүүрсний экспорт: өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 200.5 сая ам.доллар буюу 2.3 хувиар буурч, биет хэмжээгээр 14,142.5 мян.тн буюу 20.3 хувиар өссөн байна. Түүнчлэн нүүрсийг 100.0 хувь БНХАУ руу экспортолсон байна.



Алтны экспорт: Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 161.4 сая ам.доллар буюу 21.9 хувиар өсөж, биет хэмжээгээр 88.5 кг буюу 0.8 хувиар буурсан байна. Алтны 82.4 хувийг Швейцар, 17.3 хувийг АНУ руу тус тус экспортолсон байна.




Зэсийн баяжмалын экспорт: Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 693.4 сая ам.доллар буюу 26.4 хувиар, биет хэмжээгээр 170.4 мян.тн буюу 11.2 хувиар тус тус өссөн байна. Зэсийн баяжмалыг мөн 100.0 хувь БНХАУ руу экспортолсон байна.

3 ОУИТБС-ЫН ОРЛОГЫН БУС МЭДЭЭЛЛҮҮД

Гэрээний ил тод байдал

2025 оны 10-р сарын 01-ний байдлаар энэхүү мэдээллийн санд бүртгэгдсэн **1,365** гэрээний мэдээллийг байршуулсан байна




№	ГЭРЭЭНИЙ ТӨРӨЛ	ТОО
1	Орон нутагтай хамтран ажиллах гэрээ	393
2	Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээ	442
3	Газар ашиглах тухай гэрээ	130
4	Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийн гэрээ	64
5	Ус ашиглах тухай гэрээ	88
6	Ашиглалтын өмнөх гэрээ	53
7	Бүтээгдэхүүн хуваах гэрээ	26
8	Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн дагуу хийгдэх гэрээ	23
9	Газрын тосны эрлийн гэрээ	12
10	Орд ашиглах гэрээ	11
11	Тогтвортой байдлын гэрээ	11
12	Бусад	47
13	Концессын гэрээ	4
14	Хөрөнгө оруулалтын гэрээ	8
15	Гэрээний хавсралт	7
16	Бүтээн байгуулалтын гэрээ	7
17	Төрийн өмчит уул уурхайн компанийн худалдан авалтын гэрээ	2
18	Үйлчилгээний гэрээ	3
19	Хамтын ажиллагааны санамж бичиг	4
20	Тодорхойгүй	28

НИЙТ 1,363

3 ОУИТБС-ЫН ОРЛОГЫН БУС МЭДЭЭЛЛҮҮД

Эцсийн өмчлөгчийн мэдээлэл

2023 онд нийт 795 аж ахуй нэгж эцсийн өмчлөгчийн мэдээллээ тайлагнасан бол энэ жилийн хувьд **14.2 хувиар буурсан** үзүүлэлттэй байна. Тайлант онд ОУИТБС-ын цахим тайлангийн системд нийт 452 аж ахуйн нэгжийн эцсийн өмчлөгчийн мэдээлэл бүртгэгдсэн бөгөөд үүнээс 88 хувь буюу 404 нь хувь хүний түвшинд тайлагнасан байна. Мөн хувь хүний түвшинд авч үзэхэд улс төрд нөлөө бүхий 8 эцсийн өмчлөгч байна.



3 ОУИТБС-ЫН ОРЛОГЫН БУС МЭДЭЭЛЛҮҮД

Хог хаягдлын мэдээлэл

2024 онд 37 компани нийт 1,531,642,495 сая төгрөгийг хог, хаягдлын төлбөрт төвлөрүүлсэн байна.

Хог хаягдлын мэдээлэл, м3

ҮЙЛДВЭРЭЭС ГАРСАН ХОГ ХАЯГДАЛ	49,143	Энгийн	39,655
		Аюултай	9,487
УСТГАСАН ХОГ ХАЯГДАЛ	23,963	Аюултай	9,487
		Шатаасан	1,569
		Хими, физикийн аргаар	-
		Бусад	5,677
МЭРГЭЖЛИЙН ААН-Д ШИЛЖҮҮЛСЭН ХОГ ХАЯГДАЛ	25,134	Энгийн	19,100
		Аюултай	6,035

Хог хаягдлын өндөр төлбөр төлсөн 10 компани


№	КОМПАНИЙН НЭР	АЙМАГ СУМ	ТӨЛСӨН ТӨЛБӨР
1	Энержиресурс ХХК	Өмнөговь	768,851.9
2	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	Орхон	522,796
3	Эрдэнэс Таван толгой ХК	Өмнөговь	116,608
4	Хунт-Өгөөж ХХК	Өмнөговь	26,400
5	МАК Цемент ХХК	Дундговь, Дорноговь	18,813.6
6	Платинумланд ХХК	Булган	8,000
7	Саусгоби сэндс ХХК	Өмнөговь	6,066
8	Олон ихт баян ХХК	Дорноговь	6,000
9	Сора интернэшнл ХХК	Дорноговь	6,000
10	Эрдэнэмонгол ХХК	Баянхонгор	6,000

3 ОУИТБС-ЫН ОРЛОГЫН БУС МЭДЭЭЛЛҮҮД

Ус ашиглалтын мэдээлэл

2024 онд нийт **1,598,707,532.28 метр.куб** ус ашиглахаар гэрээ хийснээс **51,820,775.28 метр.куб** буюу гэрээлсэн усны **3.2 хувийг** ашигласан байна. Мөн сонгогдсон 110 компанийн хувьд ус ашигласны төлбөр **61,806,645,197.0 сая төгрөг төвлөрүүлсэн ба** ус бохирдуулсны төлбөр 887,255,559.5 сая төгрөгийн тус тус төвлөрүүлжээ.

2024 оны ус ашиглалтын хэмжээ, метр куб



2024 онд усны төлбөр төлсөн ТОП 10 компани, сая төгрөгөөр

№	КОМПАНИ	УС АШИГЛАСНЫ ТӨЛБӨР	Дүнд эзлэх хувь
1	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	30,232.9	48.9%
2	Оюутолгой ГХО	22,124.6	35.8%
3	Энержиресурс ХХК	4,693.1	7.6%
4	Цайртминерал ХХК	652,711	1.1%
5	Си Өү Эй Эл ХХК	629,638	1.0%
6	Хан алтай ресурс ХХК	549,179	0.9%
7	Шарын гол ХК	465,081	0.8%
8	Саусгоби сэндс ХХК	429,582	0.7%
9	Наран мандал энтерпрайзес ХХК	236,427	0.4%
10	Цагаан-Өвөлжөө ХХК	186,315	0.3%
НИЙТ		60,199.5	97%

3 ОУИТБС-ЫН ОРЛОГЫН БУС МЭДЭЭЛЛҮҮД

Ил тод байдал

ТӨААН-үүдийн тайлангаа ил тод болгосон эсэх

Компанийн нэр	ТӨААН нь санхүүгийн тайлан бэлтгэдэг эсэх	Санхүүгийн тайлан аудитлагдсан эсэх	НББ-ийн Олон улсын стандартын дагуу тайланг бэлтгэсэн эсэх	Олон улсын стандартын дагуу аудитласан эсэх	ТӨААН-ийн тайланг олон нийтэд ил тод болгосон эсэх
Тавантолгой ХК	тийм	-	-	-	үгүй
Эрдэнэс таван толгой ХК	тийм	тийм	тийм	тийм	тийм
Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ	тийм	тийм	тийм	тийм	тийм
Багануур ХК	тийм	тийм	тийм	тийм	тийм
Оюутолгой ХХК	тийм	тийм	тийм	тийм	үгүй
Бадрах энерги ХХК	тийм	-	-	-	үгүй
Эрдэнэс Критикал Минералс ТӨҮГ	тийм	тийм	тийм	тийм	тийм
Цемент шохой ХХК	тийм	тийм	тийм	тийм	тийм
Баянтээг ХК	тийм	тийм	тийм	тийм	тийм

Худалдан авалтын ил тод байдал

Компанийн нэр	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	Худалдан авах ажиллагааны тайлан
Тавантолгой ХК	тийм	тийм
Эрдэнэс таван толгой ХК	тийм	тийм
Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ	тийм	тийм
Багануур ХК	тийм	үгүй
Оюутолгой ХХК	үгүй	үгүй
Бадрах энерги ХХК	үгүй	үгүй
Эрдэнэс Критикал Минералс ТӨҮГ	тийм	тийм
Цемент шохой ХК	тийм	тийм
Баянтээг ХК	тийм	тийм

04



ЗӨВЛӨМЖ

ЗОРИЛТУУД		ҮР ДҮН	ХАРИУЦАХ ТАЛ	ХЯНАЛТ ТАВИХ БАЙГУУЛЛАГА	Биелэлт
Зорилт 20. 2018, 2019, оны нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх;	20.1	Мэдээллийн зөрүүтэй байдал арилна.	Ажлын алба	АҮЭБЯ, ТАН эвсэл	✓ Хуулийн төсөлд оруулсан.
	20.2	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна.	Холбогдох аймгуудын ЗДТГ	Аймгийн Аудит-ын газар, АҮЭБЯ, ТАН	✓ Хэрэгжиж эхлээд байна.
	20.3	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна.	Ажлын алба	АҮЭБЯ, ТАН эвсэл	✓ Хэрэгжиж эхлээд байна.
	20.4	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна.	Ажлын алба	АҮЭБЯ, ТАН эвсэл	✓ Хэрэгжсэн.
	20.5	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна.	Ажлын алба	АҮЭБЯ, ТАН эвсэл	✓ Хуулийн төсөлд оруулсан.
	20.6	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна.	Ажлын алба	АҮЭБЯ, ТАН эвсэл	✓ Судалж байна.
	20.7	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна.	Ажлын алба	АҮЭБЯ, ТАН эвсэл	✓ Судалж байна.
	20.8	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна.	Ажлын алба	АҮЭБЯ, ТАН эвсэл	✓ ОУИТБ-ын хуулийн төсөлд тусгасан байна.
	20.9	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна	Татварын ерөнхий газар	АҮЭБЯ, ТАН эвсэл	
	20.10	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна	АМГТГ, Ажлын алба	АҮЭБЯ	✓ Хүчинтэй байгаа тусгай зөвшөөрлийн мэдээллийг ОУИТБС-ын тайлагналын систем дээр жилд 1 удаа шинэчилж байна.
	20.11	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна	Ажлын алба	АҮЭБЯ	✓ ОУИТБ-ын хуулийн төсөлд тусгасан байна
	20.12.	Тайлан цаг хугацаандаа гарсан байна. Тайлангийн чанар сайжирсан байна.	Ажлын алба Ажлын алба	АҮЭБЯ	✓ 2026 онд сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна. ✓ Хэрэгжсэн.
Зорилт 21. 2020 оны уян хатан нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх;	21.1	Тайлангийн чанар сайжирсан байна.	Ажлын алба	АҮЭБЯ	✓ ОУИТБ-ын хуулийн төсөлд тусгасан байна.
Зорилт 22. 2021 оны уян хатан нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх;	22.1	Тайлангийн чанар сайжирсан байна.	Ажлын алба	АҮЭБЯ	✓ 2026 онд сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна.
	22.2	Тайлангийн чанар сайжирсан байна.	Ажлын алба	АҮЭБЯ	✓ Нэмэлт гэрээ байгуулж, тохиргоо хийхээр төлөвлөж байна.
	22.3	Тайлангийн хамралт сайжирсан байна	Ажлын алба	АҮЭБЯ	✓ Нэмэлт гэрээ байгуулж, тохиргоо хийхээр төлөвлөж байна.
	22.4	Тайланг ашиглах явдал сайжирсан байна.	Ажлын алба	АҮЭБЯ	✓ Нэмэлт гэрээ байгуулж, тохиргоо хийхээр төлөвлөж байна.
	22.5	Гэрээний ил тод байдал сайжирсан байна.	Ажлын алба	АҮЭБЯ, ТАН эвсэл	✓ ОУИТБ-ын хуулийн төсөлд тусгасан байна.
Зорилт 23. 2022 оны нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх;	23.1	Олон улсын стандартын шаардлагыг хангана.	Ажлын алба	АҮЭБЯ	✓ АҮЭБЯ-наас холбогдох албан тоотыг хүргүүлсэн.
	23.2	Олон улсын стандартын шаардлагыг хангана.	Ажлын алба	АҮЭБЯ	✓ АҮЭБЯ-наас холбогдох албан тоотыг хүргүүлсэн.
	22.3	Олон улсын стандартын шаардлагыг хангана.	Ажлын алба	АҮЭБЯ	✓ ОУИТБ-ын хуулийн төсөлд тусгасан байна.
Зорилт 24. 2023 оны нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх;	24.1	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна.	Ажлын алба	АҮЭБЯ	✓ 2026 онд сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна.
	24.2	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна.	Ажлын алба	АҮЭБЯ	✓ Тайлан гаргаагүй компаниудын нэрийг ил тод болгоно.
	24.3	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна.	Ажлын алба	АҮЭБЯ	✓ 2026 онд сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна.
	24.4	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна.	Ажлын алба	АҮЭБЯ	✓ 2026 онд сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна.
	24.5	Тайлагналын хяналт сайжирсан байна.	Ажлын алба	АҮЭБЯ, ТАН эвсэл	✓ 2026 оны төлөвлөгөөнд оруулна.
	24.6	Тайлагналын хяналт сайжирсан байна.	Ажлын алба	АҮЭБЯ	✓ Хүлээгдэж байна.
	24.7	Тайлагналын хяналт сайжирсан байна.	Ажлын алба	АҮЭБЯ	✓ Хэрэгжиж байна.
	24.8	Тайлагналын хяналт сайжирсан байна.	Ажлын алба	АҮЭБЯ	✓ 2026 онд сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна.
	24.9	Тайлагнах чадавх нэмэгдсэн байна.	Ажлын алба	АҮЭБЯ	✓ 5-р сарын 7-нд цахим сургалт зохион байгуулсан.
	24.1	Мэдээллийн хүртээмж сайжирсан байна.	Ажлын алба	АҮЭБЯ	✓ Нэмэлт гэрээ байгуулж, тохиргоо хийхээр төлөвлөж байна.
	24.11	Мэдээллийн чанар сайжирсан байна.	Ажлын алба	АҮЭБЯ	✓ Нэмэлт гэрээ байгуулж, тохиргоо хийхээр төлөвлөж байна.

ОУИТБС-ын 2024 оны нэгтгэлийн үр дүнгээс үзэхэд өмнөх онуудын нэгтгэлийн дүнтэй харьцуулахад мэдээлэл, тайлагналын чанар болон оролцогч талуудын идэвх буурсан нь бидэнд анхаарах асуудал байгааг илтгэж байна.

Төрийн байгууллагуудын, **ялангуяа орон нутгийн түвшний байгууллагуудын мэдээлэл дутуу, эсвэл огт ирүүлээгүй тохиолдол** байсаар байгаа бөгөөд компаниудын хувьд мөн адил алдаатай болон дутуу тайлагналын байдал үргэлжилсээр байна.

- ✓ Энэ нь техникийн төдий бус, **бодлогын түвшинд ил тод байдлын ач холбогдлыг хангалттай ойлгож, хэрэгжүүлэх соёл бүрэн төлөвшөөгүй** байгааг харуулж байна.
- ✓ Иймд цаашид ОУИТБС-ын **хэрэгжилтийн чанарыг сайжруулах, оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, ил тод байдлын тогтолцоог төлөвшүүлэх** зорилгоор дараах зөвлөмжийг гаргаж байна.

1. ИЛ ТОД БАЙДЛЫГ ЭРХ ЗҮЙН ТҮВШИНД БАТАЛГААЖУУЛАХ.

“Эрдэс баялгийн ил тод байдлын тухай хууль”-ийг яаралтай батлах эсвэл “Ашигт малтмалын тухай хууль” болон холбогдох дүрэм, журмуудад ил тод байдлын заалтыг тусгах. ОУИТБС-ын **хэрэгжилт, тайлагналын үүрэг, хяналт, урамшуулал** болон **хариуцлагын зохицуулалтыг нэг мөр болгон тодорхойлох** шаардлагатай байна.

Хууль тогтоомжийг баталснаар ил тод байдлын **стандартыг төрийн бодлогын бүрэлдэхүүн хэсэг болгон төлөвшүүлэх, төр, компани, иргэний нийгмийн оролцоог институтийн түвшинд баталгаажуулах** нөхцөл бүрдэнэ.

2. КОМПАНИУДЫН ТАЙЛАГНАЛЫН ИДЭВХ БА ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ.

- ОУИТБС-д хамрагдах компанийн үүргийг **хууль, тусгай зөвшөөрөл** болон **гэрээний нөхцөлд тусгах, тайлан гаргаагүй тохиолдолд тодорхой хариуцлага хүлээлгэх механизмыг нэвтрүүлэх шаардлагатай** байна.
- Ил тод байдлын сайн жишгийг дэмжих зорилгоор “**Ил тод компанийн үнэлгээ**”-г бий болгож, **жил бүр олон нийтэд зарлах** нь компаниудын идэвхийг нэмэгдүүлэх үр нөлөөтэй арга хэмжээ болно.
- Төрийн өмчит компанийн **Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн гүйцэтгэлийн шалгуурт ил тод байдлын үзүүлэлтийг тусгах замаар** дотоод хяналт, хариуцлагыг сайжруулах боломжтой.

3. ОРОН НУТГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ТАЙЛАГНАЛ БА ЧАДАВХЫГ БОДЛОГЫН ТҮВШИНД ДЭМЖИХ.

Орон нутгийн түвшинд ОҮИТБС-ийн хэрэгжилтийг тогтвортой, үр дүнтэй байлгахын тулд мэдээлэл хариуцсан **ажилтны чадавх, хариуцлага, байгууллагын тогтолцоог зэрэгцэн сайжруулах бодлого шаардлагатай** байна. Үүний тулд ОҮИТБС-ын мэдээлэл хариуцсан албан тушаалтны эрх зүйн болон байгууллагын байр суурийг тодорхой болгох.

Энэхүү албан тушаал нь жил бүрийн тайлангийн явц, мэдээлэл оруулах хариуцлагыг хүлээдэг байдлаар **ажлын байрны тодорхойлолт, ажлын гүйцэтгэлийн үзүүлэлтэд тусгагдах** шаардлагатай.

Түүнчлэн орон нутгийн мэдээлэл хариуцсан ажилтнуудад зориулсан тогтмол **ОҮИТБС-ын цахим тайлангийн системийн сургалт, өгөгдлийн чанарын үнэлгээ, ил тод байдлын стандарт** зэрэг чиглэлээр жил бүрийн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлбэл үр дүнтэй байх боломжтой. Мөн ОҮИТБС-ын цахим тайлангийн системтэй уялдсан **орон нутгийн ил тод байдлын дэд портал хөгжүүлж, аймаг, сум, дүүргийн орлого, зарцуулалт, хуваарилалтын мэдээллийг нээлттэй байдлаар** иргэдэд хүргэх.

4. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХООРОНДЫН УЯЛДАА, МЭДЭЭЛЛИЙН СОЛИЛЦООГ САЙЖРУУЛАХ.

ОҮИТБС-ын тайлагналын үр дүнд тулгарч буй **гол хүндрэлүүдийн нэг нь төрийн байгууллагуудын хоорондын мэдээллийн уялдаагүй ажиллагаа** байсан.

Тухайн байгууллагаас мэдээлэл хүсэхэд зарим байгууллага **хариу өгөхгүй** эсвэл **мэдээлэл өгөхөөс зайлсхийх, мэдээллийг бүрэн бус өгөх** зэрэг хүндрэлүүд давтагдсаар байна.

Үүнээс шалтгаалан ОҮИТБС-ын тайлан гаргах явцад шаардлагатай өгөгдлийг бүрэн авах боломжгүй болж, **тайлангийн чанар буурах эрсдэл үүсгэж** байна. Иймд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг санал болгож байна:

- ✓ Мэдээлэл шаардах, хүлээн авах үйл явцын хариуцлагыг тодорхой болгож, тайлан боловсруулах явцад бүх талын мэдээллийг цаг хугацаанд нь өгөх үүрэг хүлээлгэх.
- ✓ Мэдээлэл өгөхгүй, хоцорсон, дутуу мэдээлэл өгсөн байгууллага, ажилтанд хариуцлагын арга хэмжээ авах.
- ✓ Төрийн байгууллагын ажилтнуудад ОҮИТБС-ын тайлагналын стандартыг ойлгох, мэдээлэл цаг тухайд нь өгөх, бусад байгууллагатай уялдан ажиллах чиглэлээр сургалт зохион байгуулах.

5. ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН МОНИТОРИНГИЙН ҮҮРГИЙГ ДЭМЖИХ.


ОҮИТБС-ын гол зарчмуудын нэг нь “**олон талын оролцоо, хяналт, хариуцлага**” бөгөөд үүнд иргэний нийгмийн байгууллагууд чухал үүрэгтэй. Гэвч өнөөгийн нөхцөлд ИНБ-ууд **мэдээлэлд хандах боломж хязгаарлагдмал, техникийн чадавх сул, мониторингийн дүн бодлогын шийдвэрт тусгагдахгүй байх** хүндрэл байсаар байна.

Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд дараах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг санал болгож байна:

- ✓ Иргэний нийгмийн байгууллагын мониторингийн эрх зүйн үндсийг бэхжүүлэх.
- ✓ Ил тод байдлын мониторинг, өгөгдлийн шинжилгээний чиглэлээр ИНБ-уудыг дэмжих санхүүжилтийн болон техникийн тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх.

6. ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН МОНИТОРИНГИЙН ҮҮРГИЙГ ДЭМЖИХ.

УТГА	ЗӨВЛӨМЖ
Гаалийн албан татвар/ Гаалийн НӨАТ андуурагдсан хэвээр, Энэ жил орон нутагт төвлөрүүлдэг татварын дүнгүүд улсын төсвийн татварын дүнгүүдтэй залруулагдсан алдаа их илэрсэн	✓ Мэргэжлийн байгууллагатай хамтран тайлан илгээх компаниудыг мэдээллээр тогтмол хангах. Байнгын гардаг залруулга татварын төрлүүд, татварын мөнгөн сууриар тайланг шивэх талаар мэдээллээр тогтмол хангах.
Татварын мөнгөн сууриар бус аккрузал сууриар илгээсэн зөрүү,	✓ Ил тодын тайлангийн загвар байдлаар хэрхэн бөглөх мэдээллийг бичлэг хэлбэрээр байршуулан гарын авлагыг ил тод оруулах
Орон нутгаас ахин мэдээлэл дутуу ирсэн	✓ Засгийн газрын хамтран ажилладаг байгууллагуудыг мэдээллээр ханган мэдээлэл хуваалцах ач холбогдлыг тайлбарлах.
Компани, Засгийн газар талаас аль аль нь мэдээлэл муу байгаагаас дээрх зөрүү илэрсэн	✓ Энэхүү мэдээлэл нийтэд ил болсноор бий болох давуу тал үүний ач холбогдлыг болон тайлангаас хэрхэн мэдээллээ зөв ойлгон авах талаар ойлголтыг тогтмол өгөх.



**АНХААРЛ
ХАНДУУЛСАН ТАНД
БАЯРЛАЛАА**